



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 10 сарын 25 өдөр

Дугаар 462

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, 30 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, 2022 оны 204 дүгээр тогтоолын 1, 2 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 502,612,431.50 (таван зуун хоёр сая зургаан зуун арван хоёр мянга дөрвөн зуун гучин нэгэн төгрөг тавин мөнгө) төгрөгийн балансын үнэ, 92,025,876.56 (ерэн хоёр сая хорин таван мянга найман зуун далан зургаан төгрөг тавин зургаан мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийг хавсралтад заасны дагуу "Үндэсний шигшээ багийн бэлтгэл сургалтын төв" төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар, "Зам тээврийн хөгжлийн төв" төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар, "Засгийн газрын автобааз" улсын төсөвт үйлдвэрийн газарт тус тус балансаас балансад шилжүүлэхийг зөвшөөрсүгэй.

2.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга Н.Ганболд, "Үндэсний шигшээ багийн бэлтгэл сургалтын төв" төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын захирал Б.Наран-Идэр, "Зам тээврийн хөгжлийн төв" төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын захирал Х.Пүрэвжаргал, "Засгийн газрын автобааз" улсын төсөвт үйлдвэрийн газрын захирал Г.Чинзориг нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2022 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ

137003744
25-r_huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2022 оны... дугаар сарын... бөдрийн
... дугаар тогтоолын хавсралт

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, "ҮНДЭСНИЙ ШИГШЭЭ
БАГИЙН БЭЛТГЭЛ СУРГАЛТЫН ТӨВ", "ЗАМ ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ" ТӨРИЙН ӨМЧИТ АЖ АХУЙН ТООЦООТ
ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР, "ЗАСГИЙН ГАЗРЫН АВТОБААЗ" УЛСЫН ТӨСӨВТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАРТ БАЛАНСААС
БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Үндсэн хөрөнгийн нэр, марк, арал, хөдөлгүүрийн дугаар	Ашиглалтад орсон, бүртгэсэн орсон он	Нийт гүйлт /км/	Балансын нийт үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)	Шилжүүлэн авах хуулийн этгээдийн нэр
1	Тоёото хайс 56-50 УНУ (арал-jtfsx22p506156324)	2015/2021	181053	65,000,000.00	16,250,000.04	48,749,999.96	"Үндэсний шигшээ багийн бэлтгэл сургалтын төв" ТӨААТҮГ
2	Хьюндай соната-6, 10-62 УБЯ (арал-kmhet41ар9а535555)	2008/2020	18020	4,196,431.50	2,659,394.79	1,537,036.71	"Зам тээврийн хөгжлийн төв" ТӨААТҮГ
3	Тоёота ландкрузер-200, 66-35 УБК (арал-itmcsu09j104011319)	2007/2022	243275	15,000,000.00	1,249,999.98	13,750,000.02	"Засгийн газрын автобааз" улсын төсөвт үйлдвэрийн газар
4	Хьюндай игуус 14-42 УНУ (арал-kmngfh41cbcu045889)	2011/2021	97680	29450000	11,043,749.97	18,406,250.03	
5	Лексус 570-J200, 20-03 УЕА (арал-jtjhyuow404311484)	2019/2022	11000	309,966,000.00	20,664,400.00	289,301,600.00	"Засгийн газрын автобааз" улсын төсөвт үйлдвэрийн газар
6	Хьюндай соната LF, 38-99УБҮ (арал -kmhe41cbka510777)	2019/2020	53481	79,000,000.00	40,158,331.78	38,841,668.22	
	Нийт дүн			502,612,431.50 (таван зуун хоёр сая зургаан зуун арван хоёр мянга дөрвөн зуун гучин нэгэн төгрөг тавин мөнгө)	92,025,876.56 (ерэн хоёр сая хорин таван мянга найман зуун далан зургаан төгрөг тавин зургаан мөнгө)	410,586,554.94 (дөрвөн зуун арван сая таван зуун наян зургаан мянга таван зуун тавин дөрвөн төгрөг ерэн дөрвөн мөнгө)	